ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/25 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн санал, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг харгалзан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/108 дугаар захирамжийн тээврийн хэрэгсэл худалдах 2 дугаар хавсралтад дараах өөрчлөлтийг оруулж, жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан хөрөнгийг байгууллагынхаа данс бүртгэлээс хасах, актлах ажлыг зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

а. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

б. Худалдсан, актлагдсан тээврийн хэрэгслийг “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулсан, шилжүүлсэн тухай тайланг ирүүлэх.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Г.МӨНГӨНХУЯГ

6710001049

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны
өдрийн А/25 дугаар захирамжийн хавсралт

а/ Тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл үнэ /мян.төг/	Тайлбар	Байгууллагын санал /төг/	ОНӨГ-ын үнийн санал /төг /	Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг /
1	Аймаг	Аймгийн Засаг даргын Тамгын газар	УАЗ-220695, 44-18 ХӨВ	2016	ш	1	26,000,000.00	26,000,000.00	0.00	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03 сарын 27-ны өдрийн 3/537 дугаар албан бичиг	Актлах	Актлах	Актлах
Дүн							**26,000,000.00**	**26,000,000.00**	**-**				

оОо